



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 16 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 16 дугаар хуралдааныг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 16 дугаар хуралдаанаар /2025-07-30/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 8 (Тогтоол №164-171, 2025-07-30) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 16 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 8 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 8 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 164 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Ти ар планинг ХХК; Нью бест констракшн ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 165 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Силвер стэндс ХХК, 12100650 тоот; Бест оптек сервис ХХК, 12100450 тоот: Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) 5 жилийн хугацаагаар сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 166 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Эм жи эл радио ньус ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800186 тоот тусгай зөвшөөрөл, Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио

давтамжийн зурвас ашиглах” 22800192 тоот тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 167 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Миний монгол энтертайнмент ХХК: Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000047 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 168 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Говийн долгион мэдээллийн төв ТББ: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” 13000070 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Айрон товер ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 169 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Айрон товер ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх” /улс хооронд/ 17200005 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 170 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдэд 4 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 171 тоот тогтоолыг баталж, тогтоолоор суурин холбооны ярианы үйлчилгээнд зориулан 213Х-XXXX, 2145-XXXX дугаарлалт бүхий нэг зуун арван мянган сүлжээний дугаарыг тус компанийн Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх 14200001 тоот зөвшөөрлийн хүчинтэй хугацаагаар буюу 2035 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр хүртэл Монголын цахилгаан холбоо ХК-д олгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <https://crc.gov.mn/documents/xxzx-togtool> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-08-13